

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/94/НА-СТА-ТШЗ

<p>Баянхонгор аймаг 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mm</p> <p>Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mm</p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг Altantuyam@audit.gov.mm</p> <p>Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhendl@audit.gov.mn</p> <p>Цахим хуудас: www.audit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Агуулга

2.Аудитын санал дүгнэлт /эх хувь/	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт	14
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Албан шаардлага.....	15
4.3 Аудитын зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/59

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар нь:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 57600.0 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд

D:\2022-A4 тоот.docx

0050?0351

захирагч хэрэгжүүлж ажиллаагүй байна” гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 67.2 дахь заалт “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>89914194.00</u>	<u>104203455.84</u>
33	АВЛАГА	28,139,744.00	32,216,800.84
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	3,762,078.00
335	Бусад авлага	28,139,744.00	28,454,722.84
3351	Байгууллагаас авах авлага	00.00	314,978.84
3352	Хувь хүмүүсээс авах авлага	28,139,744.00	28,139,744.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,774,450.00	71,986,655.00
354	Хангамжийн материал	60,784,450.00	70,996,655.00
35410	Бичиг хэргийн материал	835,500.00	1,386,000.00
35420	Аж ахуйн материал	58,346,155.00	68,388,155.00
35440	Түлш, шатах тослох материал	1,602,795.00	1,222,500.00
35600	Мал амьтад	990,000.00	990,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,479,057,011.40</u>	<u>2,407,638,139.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,479,057,011.40	2,407,638,139.93
392	Биет хөрөнгө	2,450,648,021.80	2,379,257,509.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,555,230,090.69	2,555,230,090.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-234,138,175.76	-298,091,753.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,202,800.00	139,202,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-99,486,797.44	-102,474,597.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	198,054,954.00	219,315,474.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,400,548.67	-167,931,160.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,915,600.00	50,666,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,729,901.02	-16,659,444.37
393	Биет бус хөрөнгө	28,408,989.60	28,380,630.24
39301	Програм хангамж	552,500.00	552,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-281,510.40	-309,869.76
39303	Бусад биет бус хөрөнгө	28,138,000.00	28,138,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,568,971,205.40</u>	<u>2,511,841,595.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>166,847.00</u>	<u>364,727.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	166,847.00	364,727.00
413	Өглөг	166,847.00	364,727.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,247.00	364,727.00
4136	Бусад өглөг	159,600.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	159,600.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,568,804,358.40</u>	<u>2,511,476,868.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,568,804,358.40	2,511,476,868.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	494,690,961.00	494,690,961.00
51101	Өмч: - төрийн	494,690,961.00	494,690,961.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,876,964,771.07	1,819,637,281.44
51210	Өмнөх үеийн үр дүн	1,876,964,771.07	1,876,964,771.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-57,327,489.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,148,626.33	197,148,626.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,568,971,205.40</u>	<u>2,511,841,595.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	808,832,409.00	501,892,659.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	341,830,576.00	20,066,520.00
120	Нийтлэг татварын бус орлого	341,830,576.00	20,066,520.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	341,830,576.00	20,066,520.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	339,830,576.00	20,066,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	467,001,833.00	481,826,139.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,717,133.00	18,374,139.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,040,000.00	2,718,592.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,347,293.00	4,209,872.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,329,840.00	11,445,675.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	442,284,700.00	463,452,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	442,284,700.00	463,452,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	535,013,570.38	559,220,148.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	535,013,570.38	559,220,148.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	505,595,758.38	528,251,543.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,212,351.00	245,902,558.00
210101	Үндсэн цалин	251,212,351.00	245,902,558.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,272,139.00	31,429,343.16
210201	Тэтгэврийн даатгал	21,510,488.00	21,890,858.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,512,123.00	2,459,026.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,009,699.00	1,967,220.00
210204	Ажилгүйдлийн даатгал	476,349.00	469,821.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,763,480.00	4,642,418.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,036,829.00	53,255,730.00
210301	Гэрэл, цахилгаан	3,159,829.00	3,263,730.00
210302	Түлш, халаалт	50,770,000.00	49,992,000.00
210303	Цэвэр, бохир ус	107,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,423,050.00	41,039,114.00
210401	Бичиг хэрэг	3,358,980.00	2,944,410.00
210402	Тээвэр, шатахуун	15,202,460.00	18,559,186.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,949,610.00	4,627,934.00
210404	Ном, хэвлэл	00.00	49,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	4,788,084.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	852,000.00	10,070,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,291,940.00	150,000.00
210604	Урсгал засвар	2,291,940.00	150,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,986,000.00	4,926,000.00
210702	Дотоод албан томилолт	5,491,000.00	4,926,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	495,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,385,129.00	13,352,287.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,135,015.00	13,281,287.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	26,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,114.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,988,320.38	138,196,511.47

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,387,130.00	44,766,620.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,601,190.38	93,429,891.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,417,812.00	30,968,605.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,541,756.00	764,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,157,756.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	384,000.00	764,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,876,056.00	30,204,605.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,430,350.00	30,204,605.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>273,818,838.62</u>	<u>-57,327,489.63</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,645,833.06	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,645,833.06	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-11,645,833.06	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>262,173,005.56</u>	<u>-57,327,489.63</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>469,001,833.00</u>	<u>481,826,139.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,000,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,000,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>467,001,833.00</u>	<u>481,826,139.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,717,133.00	18,374,139.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,040,000.00	2,718,592.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,347,293.00	4,209,872.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,329,840.00	11,445,675.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	442,284,700.00	463,452,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	442,284,700.00	463,452,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>469,001,833.00</u>	<u>467,852,139.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>469,001,833.00</u>	<u>467,852,139.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>412,828,277.00</u>	<u>432,946,456.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,588,199.00	244,240,000.00
210101	Үндсэн цалин	217,930,104.92	205,251,800.00
210102	Нэмэгдэл	31,658,094.08	38,988,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,870,755.00	32,972,384.00
210201	Тэтгэврийн даатгал	23,276,524.00	23,202,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,509,724.00	2,442,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,739,281.00	1,954,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	456,448.00	488,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,888,778.00	4,884,784.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,765,670.00	52,850,161.00
210301	Гэрэл, цахилгаан	9,410,920.00	3,268,561.00
210302	Түлш, халаалт	44,354,750.00	49,581,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,602,316.00	25,304,891.00

Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,725,520.00	2,318,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,295,470.00	13,341,611.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,891,600.00	3,891,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	198,680.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,726.00	4,961,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	594,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,761,400.00	1,702,600.00
210604	Урсгал засвар	1,761,400.00	1,702,600.00
2107	Томилолт, зочны зардал	7,490,450.00	4,926,000.00
210702	Дотоод албан томилолт	5,491,000.00	4,926,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,999,450.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,583,187.00	15,790,386.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,018,789.00	15,706,386.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	26,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	58,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	564,398.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,166,300.00	55,160,034.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,166,300.00	55,160,034.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,173,556.00	34,905,683.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,297,500.00	939,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,297,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	939,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,876,056.00	33,966,683.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,430,350.00	30,204,605.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	13,974,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	13,974,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	13,974,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	13,974,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	13,974,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-13,974,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,876,964,771.07	2,568,804,358.40
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,876,964,771.07	2,568,804,358.40
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,876,964,771.07	2,568,804,358.40
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-57,327,489.63	-57,327,489.63
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,819,637,281.44	2,511,476,868.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	464,452,000.00	433,247,395.00	31,204,605.00	93.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,452,000.00	433,247,395.00	31,204,605.00	93.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,452,000.00	432,308,395.00	31,143,605.00	93.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,240,000.00	244,240,000.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	205,251,800.00	205,251,800.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	38,988,200.00	38,988,200.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,972,400.00	32,972,384.00	16.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	23,202,800.00	23,202,800.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,954,000.00	2,442,400.00	-488,400.00	124.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,442,400.00	1,954,000.00	488,400.00	80.00
210204	Ажилгүйдлийн даатгал	488,400.00	488,400.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,884,800.00	4,884,784.00	16.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,251,600.00	52,850,161.00	2,401,439.00	95.65
210301	Гэрэл, цахилгаан	5,670,000.00	3,268,561.00	2,401,439.00	57.65
210302	Түлш, халаалт	49,581,600.00	49,581,600.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,248,100.00	25,304,891.00	4,943,209.00	83.66
210401	Бичиг хэрэг	2,318,100.00	2,318,100.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	16,749,000.00	13,341,611.00	3,407,389.00	79.66
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,891,000.00	3,891,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	330,000.00	198,680.00	131,320.00	60.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,360,000.00	4,961,500.00	1,398,500.00	78.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	594,000.00	6,000.00	99.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,653,200.00	15,676,600.00	4,976,600.00	75.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,600,000.00	13,974,000.00	1,626,000.00	89.58
210604	Урсгал засвар	5,053,200.00	1,702,600.00	3,350,600.00	33.69
2107	Томилолт, зочны зардал	6,395,500.00	4,926,000.00	1,469,500.00	77.02
210702	Дотоод албан томилолт	6,395,500.00	4,926,000.00	1,469,500.00	77.02
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,187,000.00	1,178,325.00	8,675.00	99.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,100,000.00	1,094,325.00	5,675.00	99.48
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	26,000.00	1,000.00	96.30
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	58,000.00	2,000.00	96.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72504200.00	55160034.00	17,344,166.00	76.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,504,200.00	55,160,034.00	17,344,166.00	76.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00	939000.00	61,000.00	93.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	939,000.00	61,000.00	93.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	939,000.00	61,000.00	93.90
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	464,452,000.00	463,452,000.00	1,000,000.00	99.78
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	463,452,000.00	463,452,000.00	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	463,452,000.00	463,452,000.00	0.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.00

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	24	100
620001	Удирдах ажилтан	9	9	9	100
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	11	100
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,271,427.00	18,374,139.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,271,427.00	18,374,139.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,271,427.00	14,612,061.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,271,427.00	14,612,061.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,762,078.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,445,706.00	3,762,078.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,717,133.00	18,374,139.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,717,133.00	18,374,139.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,040,000.00	2,718,592.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,347,293.00	4,209,872.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,329,840.00	11,445,675.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,445,706.00	3,762,078.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 1/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын дарга Р.Болормаа, нягтлан бодогч М.Мягмарсүрэн хоёрдугаар гарын үсгийг зурсан байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Эрдэнэцогт сумын ЗДТГ нь нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн дагуу иргэдэд төр, нийгмийн үйлчилгээг үзүүлэх, сумын хэмжээнд төрийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллагын 2021 оны батлагдсан төсөв 464,452.0 мянган төгрөг, нийт 24 орон тоотой бөгөөд багийн засаг дарга 6 ажиллаж байна.

Эрдэнэцогт сумын ЗДТГ нь: Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн дагуу нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийгэм эдийн засгийн төлөвлөлтийг бодлогын удирдамжаар хангах хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулан төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, шударга байдал, ур чадварыг дээшлүүлэн төрийн бүх үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргах зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь 2021 онд боловсруулсан “Төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 535,013.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,025.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 5,216.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 5,452.4 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,129.6 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,914.2	104,203.5	14,289.3
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	28,139.7	32,216.8	4,077.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	61,774.5	71,986.7	10,212.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,479,057.0	2,407,638.1	(71,418.9)
Үндсэн хөрөнгө	2,985,093.9	2,993,105.0	8,011.0
Хуримтлагдсан элэгдэл	(506,036.9)	(585,466.8)	(79,429.9)
Нийт хөрөнгө	2,568,971.2	2,511,841.6	(57,129.6)
Өр төлбөр	166.8	364.7	197.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,568,804.4	2,511,476.9	(57,327.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,568,971.2	2,511,841.6	(57,129.6)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Авлагын дансны үлдэгдэл 4,077.1 мянган төгрөгөөр өссөн нь санхүүгийн тайлангаар залруулсан 315.0 мянга, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 3,762.1 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 71,986.7 мянган төгрөг болж 10,212.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 46,791.9 мянга, аймгийн Онцгой комиссоос үнэ төлбөргүй олгосон эрүүл мэндийн багц 8,645.0 мянга, аймгийн Засаг даргын Тамгын газар, сумын Орон нутгийн хөгжлийн сан, аймгийн сонгуулийн хорооноос үнэ төлбөргүй олгосон нийт 3,384.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй авсан бөгөөд 48,109.2 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 500.0 мянган төгрөгийг өртөгтэй зурагтыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,993,105.0 мянган төгрөг болж 8,011.0 мянган төгрөгөөр өссөн аймгийн Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгосон 4,807.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, аймгийн Мал эмнэлгийн газраас олгосон 1,978.9 мянган төгрөгийн компьютер, төсвийн хөрөнгөөр 13,974.0 мянга, шилжүүлэн авсан 1,250.5 мянга, нийт 22,011.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч бүртгэсэнтэй холбоотой бөгөөд тайлант онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 139 дүгээр тогтоолоор 14,000.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 364.7 мянган төгрөг буюу 197.9 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдаас суутгасан Үйлдвэрчний эвлэлийн мөнгийг шилжүүлээгүйгээс үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,511,476.9 мянган төгрөг болж 57,327.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 57,327.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 418,112.8 мянган төгрөгөөр, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,555.4 мянган төгрөгөөр бууруулж 415,557.4 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 2 удаа өөрчлөлт хийж 2021 оны 12 дугаар сард 464,452.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 463,452.0 мянга, өөрийн орлогоос 1,000.0 мянган нийт 464,452.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 464,452.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 433,247.4 мянган төгрөгийг зарцуулж 30,204.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 433,274.4 мянган төгрөг буюу 93.28 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,401.4 мянга, хангамж бараа материалын

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
зардал 4,934.2 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 4,976.6 мянга, томилолтын зардал 1,469.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 8.7 мянга, бараа үйлчилгээний зардал 17,344.2 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 61.0 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2,718.6 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 4,209.9 мянга, иргэд сумын Онцгой комисст олгосон хандив 4,490.0 мянга, түрээсийн орлогоос 6,387.9 мянга, усны картын орлогын 5 хувь 567.7 мянга, нийт 18,374.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн А/438 дугаартай “Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах тухай” захирамжийн дагуу бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 14,612.1 мянган төгрөгийг зарцуулж, 3,762.0 мянган төгрөгийн харилцахын үлдэгдлийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 558,025.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 23,012.0 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тус сумын Засаг даргаар ажиллаж байсан Ц.Төмөрбаатарт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 39,297.5 мянган төгрөгийг олгосон бөгөөд илүү олгосон 28,139.7 мянган төгрөгийг 2020 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар авлагаар тусгуулсан бөгөөд дээрх 39,297.5 мянган төгрөгийг Авлигатай тэмцэх газрын хохирлын нөхөн төлбөр 100900000717 тоот дансанд тушаасан боловч тус байгууллагын авлагыг хаах шийдвэр ирээгүй Тул авлагыг хааж бууруулаагүй.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 481,826.1 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 475,106.1 мянган төгрөгийн 135 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчиж 14,220.0 мянган төгрөгийн 14 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	86	10	
	Нийт	27	151	135	14	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 464,452.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 433,247.4 мянган төгрөгийг зарцуулж 30,204.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 464,452.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэл 433,247.4 мянган төгрөгөөс цалин, нийгмийн даатгалын шимтгэл болон тогтмол зардлын дүнг хасаад 142,173.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд оны эцэст үндсэн үйл ажиллагааны зардлаас 25,097.8 мянган төгрөг буюу төсвийн 17.6 хувийг буцаан төвлөрүүлсэн байна.

Харин байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 58,957.0 мянган төгрөгөөр баталж 52,850.2 мянган төгрөгийг зарцуулж санхүүжилтээр 3,705.4 мянган төгрөгийг суутган тооцож, оны эцэст 2401.4 мянган төгрөг буюу төсвийн 10.3 хувийг буцаан Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцээгүй байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 105,187.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 47,587.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 57,600.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021.06.14-ны өдрийн 48 дугаартай албан бичгээр ирүүлснээс 57,600.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 26,000.0 мянган төгрөгийн хог тээврийн автомашин, 13,950.0 мянган төгрөгийн ачааны автомашиныг сумын ЗДТГ хөрөнгөдөө шийдвэр гараагүй тул бүртгээгүй байна. Иймд аймгийн ОНХС-ын 2021 оны санхүүгийн тайланд дээрх хөрөнгийг орлого авах шийдвэр гараагүй байгаа тул сангаас шилжүүлсэн мөнгөн дүнгээр бараа материалын нөөц хөрөнгөөр бүртгэсэн эсэхийг хянаж, аймгийн ТЕЗ-ийн тайланд асуудлыг авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 61,049.2 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1,194.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 59,854.6 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 5 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Үндсэн хөрөнгийн тавилга эд хогшил дансны хуримтлагдсан элэгдэл санхүүгийн тайланд 15,464.9 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 16,659,4 мянган төгрөгөөр буюу 1,194.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.35. “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө” гэснийг заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зөрүү 1,194.6 мянган төгрөгийг залруулан санхүүгийн тайланд тусгуулав.

4.2 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1.Тус байгууллагын барилга, байгууламж дансанд бүртгэлтэй 8.472.1 мянган төгрөгийн өртөг бүхий гүнийн худгийг иргэн Бямбасүрэнд үнэ төлбөргүй ашиглуулж, түрээсийн гэрээ байгуулаагүй байна.

Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь аймгийн ИТХ-ын Хуралдааны 2020.09.18-ны өдрийн 21/02 дугаартай тогтоолоор баталсан" Түрээсийн гэрээний загвар, жишиг үнийг шинэчлэн батлах тухай журам"-ын нэгдүгээр хавсралтын 2.1 дэхь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын төвийн цэвэр усны гүний худгийг ашиглуулах талаар түрээсийн гэрээг байгуулж Орон нутгийн өмчийн газраар баталгаажуулан орлогыг тухай бүх нь байгууллагын дансанд төвлөрүүлэх.

2. Шилэн дансны цахим сайтад нийт 481,826.1 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 475,106.1 мянган төгрөгийн 135 мэдээлэл оруулсан бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14,220.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ болон нийт 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

3. Тус байгууллага нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 58,957.0 мянган төгрөгөөр баталж 52,850.2 мянган төгрөгийг зарцуулж нийт 11,791.4 мянган төгрөг хэмнэхээс санхүүжилтээр 3,705.4 мянган төгрөгийг суутган тооцож, оны эцэст 2401.4 мянган төгрөг буюу төсвийн 10.3 хувийг хэмнэсэн боловч 5,684.6 мянган төгрөгийг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

4. Баянхонгор аймгийн ОНСХ-ийн хөрөнгийн эх үүсвэрээр Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газарт БХАОНӨГ/202112023 гэрээний дагуу нийлүүлэгдсэн 26,000.0 мянган төгрөгийн хог тээврийн автомашин, 13,950.0 мянган төгрөгийн ачааны автомашиныг хүлээлгэн өгсөн боловч бүртгэлд тусгах талаар шийдвэр гараагүй тул хөрөнгийн бүртгэлд аваагүй байна.

Өгсөн зөвлөмж

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүсэлт гаргаж холбогдох шийдвэрийг гаргуулан 39,950.0 мянган төгрөгийн 2 автомашиныг орлого авч, тээврийн хэрэгслийн гэрчилгээг тухайн байгууллагын нэр дээр шилжүүлж авах талаар зөвлөмж өгөв.

5. Аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн "Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах тухай" А/438 дугаартай захирамжаар төсөвт байгууллагуудын нэмэлт орлогыг зарцуулах хуваарийг хавсралтаар батлаагүй байхад дээрх шийдвэрийг үндэслэн Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд үйлчилгээний орлогыг

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан төлөвлөөгүй атлаа байгууллагын үйл ажиллагаагаа явуулан гүйцэтгэлээр 6,387.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтын дансандаа төвлөрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2019.03.27-ны өдрийн 74 дугаартай тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дөрөвдүгээр зүйлийн 4.2 “Орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын энэ журмын 3.1.1-т заасан орлогыг зарцуулах хүсэлтийг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн алба,(цаашид “орон нутгийн санхүү, тасвийн асуудал хариуцсан нэгж” гэх) энэхүү журмын 4.1-д заасан хугацааны дотор хянаж тухайн шатны Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлнэ.гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулж, давсан орлогыг холбогдох шийдвэр гаргуулан Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаартай тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу зарцуулж алдааг дахин давтан гаргагүй байх талаар зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	4	41,144.6	1	1,194.6					3	39,950.0

Аудитын код **БНА-2022/94/НА-СТА-ТШЗ**



Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүн	4	41,144.6	1	1,194.6				3	39,950.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал									
1	Шилэн данс	1	14,220.0					1	14,220.0
2	ЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт	1	5,684.6					1	5,684.6
Дүн		2	19,904.6					2	19,904.6
НИЙТ ДҮН		6	61,049.2	1	1,194.6			5	59,854.6

_____оОо_____